



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зол халиун соронз ХХК-ийн “Соронз” зочид буудлын 17/124, Хос бэрс ХХК-ийн “Бэрс” Зочид буудлын 17/145, Ашид инж ХХК-ийн “Ашид” зочид буудлын 17/135, Бадман дэлгэрэх ХХК-ийн “Дэлгэрэх” зочид

1150500177


буудлын 17/143, Стар интер трейд ХХК-ийн "Их бүрд" зочид буудлын 17/134 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА *D. Balsan* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 06
сарын 27 өдрийн А/52 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5234325 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.06.27

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Зол халиун соронз ХХК	4552316	Соронз	НД-ийн 4-р хороо Жаргалантын 1-1
2	Хос бэрс ХХК	5009995	Бэрс	БГД-ийн 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс ЭХ-ний гудамж 41/3
3	Ашид инж ХХК	5110076	Ашид	БГД-ийн 12-р хороо Өргөө гудамж 7
4	Бадман дэлгэрэх ХХК	5047242	Дэлгэрэх	БЗД-ийн 13-р хороо Алтан тэвш АОС 93
5	Стар интер трейд ХХК	2714388	Их бүрд	ЧД-ийн 9-р хороо Энэбишийн гудамж
6	Биби девелопмент ХХК	6299857	Новотел	СБД-ийн 6-р хороо Бага тойруу Улаанбаатар 14201
7	Авдар өргөө ХХК	5234476	Жэй	СБД-ийн 1-р хороо Автозамчдын гудамж 34
8	Бодь мөр интернэшнл ХХК	2622912	Ниппон	БГД-ийн 4-р хороо Нарны зам гудамж 461-1
9	Жэй ти жэй ХХК	6231217	Амарбаясгал ант	СБД-ийн 1-р хороо ЭТӨЧ 15

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 06
сарын 27 өдрийн А/52 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ 48936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.06.27

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Их хат ХХК	5471648	89	БГД-ийн 20-р хороо үйлдвэрийн бүс 1 товчооны гудамж 9
2	Ушгар ХХК	5886783	Оюу	БЗД-ийн 7-р хороо 31-113
3	Жэй ай өү ХХК	5531365	Сайхан хангай	СХД-ийн 27-р хороо Агарын 1-15

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 06
сарын 27 өдрийн А/52 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.06.27

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монтэн бридж ХХК	5856558	Монтэн гэр лодже	НД-ийн 6-р хороо Горхи-Тэрэлж байгалийн цогцолбор газар
2	Мөнх-Үрс ХХК	2595443	Хан тэрэлж	НД-ийн 6-р хороо Онгоцотын ам 7
3	Шинэ Монгол хаад ХХК	2093391	Шинэ Монгол	БЗД-ийн 20-р хороо Хар усан тохой

-ооОоо-